



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 16 өдөр Дугаар 17 .

Хэрлэн сум

ХVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1.Баян-Уул суманд ажиллаж буй Франц улсын иргэний талаарх мэдээлэл танилцуулахыг Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

2.Баянхошуу боомтод ажилласан тухай тайлан мэдээллийг танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газрын дарга Б.Тамир нарт:

1.1 Дорнод аймгийн харьяат бусад улсаас ирсэн, явсан иргэдийн мэдээллийг бэлтгэн албан хаагчийг томилж аймгийн Засаг даргын Тамгын газар, Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газарт албан бичгээр тухай бүрт хүргүүлж байхыг,

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаад:

2.1. 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр агаарын тээврээр Испани улсаас ирсэн иргэн Б.Оргил-Эрдэнэ, 2020 оны 03 дугаар сарын 07-ны өдөр АНУ-аас ирсэн Г.Олзвой нарыг тусгаарлах байранд тусгаарлаж, эрүүл мэндийн тандалтыг үргэлжүүлэхийг,


2.2 2020 оны 03 дугаар сарын 03-нд Дорнод аймагт ирж, одоогоор Баян-уул суманд ажиллаж байгаатай холбогдуулан Франц улсын иргэн Veronique Anna-г шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ шинжилгээнд хамруулахыг,


Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.1. Ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийг боловсруулж батлуулахыг,

Дөрөв. Нийгмийн бодлогын хэлтсийн дарга О.Болормаад

4.1. Баян-уул суманд ажиллаж байгаатай холбогдуулан Франц улсын иргэн Veronique Аппа-г шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ шинжилгээнд хамруулах хүсэлтийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд албан бичгээр хүргүүлэхийг тус тус үүрэг болголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА